



**МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ**

15170 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 3,
Утас: 7600 3333, 31 06 12, Факс: (976-11) 32 29 04,
И-мэйл: info@mcud.gov.mn, Вэбсайт: www.mcud.gov.mn

2019. 04. 10 № 03/1211
танай _____ -ны № _____ -т

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГА Ц.ГАНХҮҮ ТАНАА**

Дүрэм, журам хүргүүлэх тухай

Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 07 дугаар тушаалаар байгуулсан Аж ахуйн нэгж, байгууллагад Аж ахуйн нэгж, байгууллагад Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ, Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа, Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх, тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх, хяналт тавих журам, Хот байгуулалтын баримт бичигт улсын экспертиз хийх дүрэм, журмыг шинээр болон шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг хуулийн этгээдэд олгох, хяналт тавих журам”, “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм”, “Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертэд тавигдах шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам”-ыг тус тус боловсруулж Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 53, 54 дүгээр тушаалаар тус тус батлуулж хавсралтаар хүргүүлж байна.

Шинэчлэн батлагдсан дүрэм, журмыг хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хууль, тогтоомжийн тухай хуулийн дагуу нэлэөллийн шинжилгээ болон хэлэлцүүлгийг хийж холбогдох тайланг гарган 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор манайд ирүүлэх, дүрэм журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна уу.

Шинэчлэн батлагдсан “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг хуулийн этгээдэд олгох, хяналт тавих журам”, “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм”, “Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертэд тавигдах шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам” болон Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 53, 54 дүгээр тушаалыг хавсаргав.

Хавсралт 39 хуудастай

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН

08 01542

Боловсруулсан:

Д.Бэлэгсайхан

Нийлсэн:
2 хувь Ю.Н

Д.Бэлэгсайхан

2019.04.10 18:26:56
C:\Users\nyamsuren\Desktop



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ГУШЛАЛ

2019 сны 07 сарын 26 өдөр

Дугаар 54

Урзянбаатар хот


Дүрэм, журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалт, Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм"-ийг нэгдүгээр хавсралтаар, "Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертэд тавигдах шаардлага, түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж, эрх олгох журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ дүрэм, журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (Ц.Ганхүү)-т, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Гүнболд)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 226 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


Х. ВАДЕЛХАН

Барилга, хот байгуулалтын сайдын
2019 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн
24 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ХОТ БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ, ЗӨВШӨӨРӨЛЦӨХ, ЭКСПЕРТИЗ ХИЙХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хот байгуулалтын тухай хуулийн 11.1-д заасан Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүсийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл, бусад үе шатны төсөл (цаашид “хот байгуулалтын баримт бичиг” гэх)-ийг боловсруулах, зөвшөөрөлцөх, баталгаажуулах, экспертиз хийх, хадгалах үйл ажиллагаанд энэхүү дүрмийг мөрднө.

1.2. Энэхүү дүрмийг хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага (цаашид “гүйцэтгэгч” гэх), түүнчлэн хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, хот байгуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, хянах чиг үүрэг бүхий газар, алба, захиалагч, хөрөнгө оруулагчид заавал баримтална.

Хоёр. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, түүнд тавигдах шаардлага

2.1. Захиалагчтай байгуулсан гэрээ, баталсан зургийн даалгаврыг үндэслэн хот байгуулалтын баримт бичгийг Хот байгуулалтын тухай хуулийн 11.2-т заасны дагуу хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан, сонгон шалгаруулалтаар шалгарсан аж ахуйн нэгж, байгууллага боловсруулна.

2.2. Хот байгуулалтын баримт бичгийг бэлтгэл, судалгаа, боловсруулалтын ажил гэсэн үе шатны дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:

2.2.1. Бэлтгэл үе шатанд захиалагч, гүйцэтгэгчийн хооронд гэрээ байгуулан, зургийн даалгаврыг боловсруулж батална.

2.2.2. Судалгааны үе шатанд төлөвлөлтөнд хамрагдаж буй нутаг дэвсгэрийн гадаад, дотоод орчны болон инженер хайгуул (инженер-геологи, геоморфологи, гидрологи, түүх, археологи г.м)-ын судалгаа, байгаль орчны үнэлгээ, дэвсгэр (байр зүйн) зураглал, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ хийж, суурь судалгааны нэгдсэн дүгнэлтийг боловсруулна.

2.2.3.Боловсруулалтын үе шатанд улс, бүс нутаг, хот, тосгоны болон тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн хэтийн төлөв, концепци, эскиз, хувилбарууд, төлөвлөлтийн техник, эдийн засгийн үзүүлэлт, үндсэн шийдлийг боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ (төсөл, менежмент, бүтээн байгуулалтын ажил г.м)-г тодорхойлно.

2.3.Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах зургийн даалгаврыг энэ дүрмийн нэгдүгээр болон хоёрдугаар хавсралтад заасан үлгэрчилсэн загварын дагуу боловсруулж, гуравдугаар хавсралтын дагуу зөвшөөрөлцөн батална. Захиалагч нь гүйцэтгэгчтэй хамтран зургийн даалгаврыг боловсруулж болно.

2.4.Захиалагч нь батлагдсан зургийн даалгаврын дагуу хот байгуулалтын баримт бичиг боловсруулахад шаардлагатай анхдагч мэдээллийг бэлтгэж гүйцэтгэгчид өгнө. Анхдагч мэдээлэл нь тухайн нутаг дэвсгэрийн газар ашиглалт, байгалийн нөхцөл, нөөц, түүхэн хөгжил, нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, түүх, соёлын өв, байгаль орчны хамгаалал, экологийн тэнцвэрт байдал зэрэг хууль эрх зүйн орчин, статистик, судалгаа шинжилгээ, зураглалын гэсэн үндсэн мэдээллийг багтаасан байна.

2.5.100.000 (нэг зуун мянга)-аас дээш хүн амтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг техник, эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө гэсэн 2 үе шаттай боловсруулна.

2.6.Олон улсын чанартай нисэх буудал, чөлөөт бүс болон уул уурхай, хүнд үйлдвэрийн барилгажилтаар эрчимтэй хөгжих шинэ буюу төлөвлөлтөөр оршин суух хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ нь нэмэгдэх хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг захиалагч байгууллагын хүсэлт, баталсан зургийн даалгавар, холбогдох хууль тогтоомж болон дээд шатны байгууллагын шийдвэрийг үндэслэн оршин суугчдын тооноос хамаарахгүйгээр энэ дүрмийн 2.5-д заасны дагуу 2 үе шаттайгаар боловсруулж болно.

2.7.Техник, эдийн засгийн үндэслэлийг нийгэм, эдийн засаг, хүн ам зүй, байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, газар зүйн нөхцөл, дэд бүтцийн хангамж, нөөц, төлөвлөлтийн судалгаанд тулгуурлан хот, суурин газрыг хөгжүүлэх зөв, оновчтой хувилбарыг сонгох зорилгоор боловсруулна.

2.8.Энэ дүрмийн 2.5, 2.6-д зааснаас бусад хот байгуулалтын баримт бичгийг нэг үе шаттайгаар боловсруулна. Энэ тохиолдолд техник, эдийн засгийн үндэслэл нь тайлбар бичгийн нэг бүлэг болно.

2.9.Хот байгуулалтын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, журам, заавар, аргачлал, стандартын дагуу боловсруулж, Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан "Хот байгуулалтын баримт бичигт тавигдах шаардлага"-ыг хангасан байна.

2.10.Хот байгуулалтын тухай хуулийн 17 дугаар зүйл болон холбогдох журам, зааварт заасны дагуу хот байгуулалтын баримт бичиг боловсруулахад олон нийтийн саналыг авч тусгана.

2.10.1.Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам”-ыг баримтална.

2.10.2.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл боловсруулахад Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйл, 20 дугаар зүйл, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх талбайг сонгох үлгэрчилсэн журам”-ыг тус тус баримтална.

2.11.Хот байгуулалтын баримт бичгийг боловсруулахад зөвшөөрөгдсөн програм хангамж, дэвшилтэд техник, технологийг ашиглана.

2.12.Захиалагч нь хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах явцад Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан аливаа шийдвэрийг гүйцэтгэгчид тухай бүрт нь мэдэгдэнэ.

2.13.Гадаад улсын хуулийн этгээд нь хот байгуулалтын баримт бичгийг боловсруулахдаа Монгол Улсын хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран гүйцэтгэх бөгөөд холбогдох норм, нормативын баримт бичиг, стандартыг мөрдөнө.

Гурав. Хот байгуулалтын баримт бичгийг баталгаажуулах, зөвшөөрөлцөх

3.1.Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүсийн хөгжлийн төсөл, чөлөөт бүс, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл, бусад үе шатны төслийн үндсэн зургуудын нүүр хуудас, булангийн хүснэгтэд гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын дарга (захирал), зургийн ерөнхий инженер болон зохиогч нар гарын үсэг зурна. Тайлбар бичгийн боть тус бүрийн эхний хуудаст гүйцэтгэгч байгууллагын захирал, зургийн ерөнхий инженер, түүний дараагийн хуудсанд зураг төслийн бүрдэл, агуулгын хэсэгт зохиогч нар тус тус гарын үсэг зурсан байна.

3.2.Гүйцэтгэгч нь хот байгуулалтын баримт бичигт тусгасан инженерийн бэлтгэл арга хэмжээ, нийтээр ашиглах барилга байгууламж, нийгмийн болон

инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн шийдэл, байгаль орчин, түүх, археологи, соёлын өвийг хамгаалах, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гамшигийн менежмент, хог хаягдлын менежментийн талаар холбогдох төрийн (салбарын асуудал эрхэлсэн яам, агентлаг) болон орон нутгийн захиргааны байгууллага (архитектур, хот байгуулалт, газрын харилцаа болон байгаль, түүх, соёлын дурсгалын хамгаалалт, иргэний хамгаалалт, онцгой нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх хор хөнөөлийг арилгах, инженерийн хангамж, зам, тээврийн асуудал хариуцсан алба, нэгж), төрийн хяналтын байгууллага (ариун цэвэр, эрүүл ахуй) болон аймаг, нийслэл, хотын ерөнхий архитектортой тус тус зөвшөөрөлцөнө.

3.3. Захиалагч нь тухайн хот байгуулалтын баримт бичиг боловсруулах зургийн даалгаварт зөвшөөрөлцөх байгууллагуудыг тусгайлан нэр зааж тусгана.

3.4. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах зургийн даалгаварт заагдсан зөвшөөрөлцөх байгууллагууд нь зөвшөөрөлцөхөөр илгээсэн хот байгуулалтын баримт бичгийг зохих хууль тогтоомжид заагдсан бүрэн эрхийн хүрээнд хүлээн авч, судлан үзсэний үндсэн дээр ажлын 10 өдөрт багтаан үндэслэл бүхий санал, дүгнэлтийг гүйцэтгэгч буюу захиалагчид албажуулан хүргүүлнэ. Санал, дүгнэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлээгүй тохиолдолд хот байгуулалтын баримт бичгийг зөвшөөрөлцсөнд тооцно.

Дөрөв. Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх, дүгнэлт гаргах

4.1. Захиалагч нь Хот байгуулалтын тухай хуулийн 11.6-д заасны дагуу хот байгуулалтын баримт бичигт экспертизийн дүгнэлтийг гаргуулна.

4.2. Хот байгуулалтын баримт бичгийн экспертизийг Хүснэгт 1-д заасан үе шатны дагуу ажлын 15 өдөрт багтаан хийнэ.

Хүснэгт 1

д/д	Хариуцах байгууллага, эксперт	Ажлын үе шат
1	Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	<ul style="list-style-type: none"> ▪ Хот байгуулалтын тухай хуулийн 7.1.5-д заасны дагуу улсын экспертизийн дүгнэлтийг баталгаажуулж, зохион байгуулагч байгууллагад хүргүүлэх.
2	Экспертиз хийх ажлыг зохион байгуулагч: Хот байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч	<ul style="list-style-type: none"> ▪ Захиалагчаас хот байгуулалтын баримт бичгийн иж бүрдлийг хянан хүлээн авч, экспертиз хийх гэрээг байгуулах; ▪ Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх эрх бүхий иргэн буюу

	төрийн захиргааны байгууллага	<ul style="list-style-type: none"> ■ экспертийг сонгож томилох, дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулах; ■ Экспертийн гаргасан дүгнэлтийг хүлээн авч бүртгэх, нэгдсэн дугаар олгох; ■ Улсын экспертизийн дүгнэлтийг боловсруулж, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн баталгаажуулах; ■ Баталгаажсан экспертизийн дүгнэлт, хот байгуулалтын баримт бичгийг захиалагчид хүлээлгэн өгөх, гэрээг дүгнэх; ■ Экспертизийн дүгнэлтийг архивлах; ■ Экспертизийн үйл ажиллагааны цахим мэдээллийн санг үүсгэн хөтлөх, тайлагнах; ■ Экспертизийн дүгнэлттэй холбоотой маргаантай асуудлыг холбогдох мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх.
3	<p>Экспертиз хийх ажлын гүйцэтгэгч:</p> <p>Экспертиз хийх эрх бүхий эксперт</p>	<ul style="list-style-type: none"> ■ Тухайн экспертэд хуваарилагдсан хот байгуулалтын баримт бичгийг хүлээн авч, экспертизийн дүгнэлтийг гаргах; ■ Өөрийн гаргасан экспертизийн дүгнэлтийг зохион байгуулагчид хүргүүлэх; ■ Экспертизийн дүгнэлтийн дагуу хот байгуулалтын баримт бичгийг хянаж, зөвшөөрөх.

4.3.Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийхээс өмнө төлөвлөлтөд хамрагдсан газрын дэвсгэр (байр зүйн) зураг холбогдох эрх бүхий байгууллагаар хянагдаж зөвшөөрөгдсөн, инженер хайгуул (инженер-геологи, геоморфологи, гидрогеологи)-ын судалгааны тайлан, дүгнэлт нь магадлал (экспертиз) хийгдсэн байна.

4.4.Энэ дүрмийн 2.5, 2.6-д заасан хот байгуулалтын баримт бичгийг боловсруулахаас өмнө техник, эдийн засгийн үндэслэлд экспертиз хийнэ.

4.5.Хот байгуулалтын баримт бичигт улсын экспертизийн дүгнэлтийг гаргахдаа дараах үндсэн асуудлуудыг хянаж үзнэ. Үүнд:

4.5.1.хот байгуулалтын баримт бичгийг батлагдсан гэрээ, зургийн даалгаврын дагуу боловсруулсан эсэх;

4.5.2.хот байгуулалтын баримт бичгийг холбогдох байгууллагуудтай зөвшөөрөлцөн байдал, өгсөн санал, дүгнэлтийг тусгасан эсэх;

4.5.3.хот байгуулалтын баримт бичгийн бүрдэл, үе шат, төлөвлөлтийн зарчим, үндсэн шийдэл нь даган мөрдөж байгаа хууль тогтоомж, норм, дүрэм, журам, заавар, аргачлал, стандарт болон олгогдсон техникийн нөхцөлийн дагуу боловсруулсан эсэх;

4.5.4.Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан "Хот байгуулалтын баримт бичигт тавигдах шаардлага"-ыг ханган боловсруулсан эсэх;

4.5.5.хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл нь Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 20 дугаар зүйлд нийцсэн байх;

4.5.6.Бүс нутаг, аялал жуулчлал, чөлөөт бүс, хот, суурин газрын хөгжлийг төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө болон олон улсын хот байгуулалт, төлөвлөлтийн хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн төлөвлөсөн эсэх;

4.5.7.Бүс нутаг, хот, суурин газарт иргэдийн амьдрах, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх, нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлыг иж бүрнээр шийдвэрлэхээр төлөвлөсөн эсэх;

4.5.8.Бүс нутаг, аялал жуулчлал, чөлөөт бүс, хот, суурин газрын нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлтийг улс, орон нутгийн нөхцөл нөөц, дэвшилтэт техник, технологид тулгуурлан үр ашигтай хувилбараар боловсруулсан эсэх;

4.5.9.Хот, суурин газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;

4.5.10.Түүх, археологи, соёлын өв, байгаль орчныг хамгаалах, хотжилтоос хүрээлэн буй орчинд нөлөөлөх сөрөг үр дагаварыг арилгах, нөхөн сэргээхээр төлөвлөсөн арга хэмжээ хангалттай эсэх.

4.6.Улсын экспертизийн дүгнэлтийг 2 (хоёр) хувь хийж баталгаажуулан, эксперт тус бүрийн гаргасан дүгнэлтийг хавсаргана.

4.7.Улсын экспертизийн дүгнэлт нь дараах агуулгыг багтаасан байна. Үүнд:

4.7.1.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үндэслэл, зорилго, ерөнхий өгөгдөл болон техник, эдийн засгийн үзүүлэлт, төлөвлөлтийн үндсэн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт;

4.7.2.төлөвлөлтийн үндсэн шийдэл, техник, эдийн засгийн үзүүлэлтэд экспертиз хийх явцад орсон нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт;

4.7.3.тухайн баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, норм, дүрэм, журам, заавар, аргачлал, стандарт болон экспертизийн үндсэн шаардлагыг хангасан бол зөвшөөрсөн, түүнийг хангаагүй зөрчсөн бол хүчингүйд тооцох тухай дүгнэлт.

4.8.Улсын экспертизийн дүгнэлтээр зөвшөөрөгдсөн нь тухайн хот байгуулалтын баримт бичгийн батлуулах үндэслэл болно. Зөвшөөрөгдсөн 1 (нэг) хувь хот байгуулалтын баримт бичигт экспертийн хувийн болон экспертиз хийгдсэн дардасыг дарна.

4.9.Улсын экспертизийн дүгнэлтээр хүчингүйд тооцсон хот байгуулалтын баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулж, энэ дүрэмд заасан шаардлагыг хангасны үндсэн дээр экспертиз хийлгэх хүсэлтийг захиалагч дахин гаргаж болно.

4.10.Экспертизийн дүгнэлттэй холбоотой маргаантай асуудлыг холбогдох мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, шийдвэрлүүлж болно.

4.11.Хот байгуулалтын баримт бичгийн экспертиз хийх үйл ажиллагааны бүртгэл, мэдээллийн санг хот байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллага хариуцан эрхэлж, тайланг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хагас жил тутамд хүргүүлнэ.

4.12. Хот байгуулалтын тухай хуульд заасны дагуу хот байгуулалтын баримт бичгийг батална.

Тав. Хот байгуулалтын баримт бичгийг хадгалах

5.1.Экспертиз хийгдсэн хот байгуулалтын баримт бичгийг цахим (PDF форматаар CD дээр бичиж) хэлбэрээр экспертиз хийх ажлыг зохион байгуулагч байгууллагын архивт холбогдох хууль тогтоомжийн дагуу хадгална.

-----o0o-----

“Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах,
зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм”-ийн
нэгдүгээр хавсралт

Үлгэрчилсэн загвар

БАТЛАВ.

НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГ
БОЛОВСРУУЛАХ ЗУРГИЙН ДААЛГАВАР

... он... сар ... өдөр

Дугаар.....

1. Боловсруулах үндэслэл
2. Байршил, эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдал
3. Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ (га)
4. Боловсруулах ажлын үе шат
5. Боловсруулахад ашиглах материал
6. Баримт бичгийн бүрдэл
7. Шийдвэрлэх үндсэн асуудлууд
8. Дэд бүтцийн хангамж, эх үүсвэр (инженерийн болон нийгмийн)
9. Орон сууцны хангамж
10. Төслийн онцгой нөхцөл
11. Боловсруулах хугацаа
12. Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр
13. Захиалагч байгууллага
14. Гүйцэтгэгч байгууллага
15. Зөвшөөрөлцөх байгууллага

ХЯНАСАН:

БОЛОВСРУУЛСАН:

“Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах,
зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм”-ийн
хоёрдугаар хавсралт

Үлгэрчилсэн загвар

БАТЛАВ.

ХОТ, ТОСГОНЫ ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ,
ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ
ЗУРГИЙН ДААЛГАВАР

... он... сар ... өдөр

Дугаар.....

1. Боловсруулах үндэслэл
2. Байршил, эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдал
3. Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ (га)
4. Боловсруулах ажлын үе шат
5. Боловсруулахад ашиглах материал
6. Баримт бичгийн бүрдэл
7. Шийдвэрлэх үндсэн асуудлууд
8. Инженерийн бэлтгэл ажил
9. Инженерийн дэд бүтцийн хангамж, эх үүсвэр
10. Нийгмийн дэд бүтцийн хангамж
11. Орон сууцны хангамж
12. Төслийн онцгой нөхцөл
13. Боловсруулах хугацаа
14. Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр
15. Захиалагч байгууллага
16. Гүйцэтгэгч байгууллага
15. Зөвшөөрөлцөх байгууллага

ХЯНАСАН:

БОЛОВСРУУЛСАН:

“Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах,
зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм”-ийн
туравдугаар хавсралт

**ХОТ БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ
ЗУРГИЙН ДААЛГАВРЫГ ЗӨВШӨӨРӨЛЦӨХ, БАТЛАХ**

д/д	Хот байгуулалтын баримт бичгийн нэр	Зөвшөөрөлцөх	Батлах
I. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг			
1	Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл	Хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Монгол Улсын Засгийн газар
2	Бүсийн хөгжлийн төсөл	Хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, тухайн бүсийн зөвлөл	Хот байгуулалтын асуудал эрхэлсэн сайд
3	Чөлөөт бүсийн хөгжлийн төсөл	Хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Чөлөөт бүсийн ажлын алба	Хот байгуулалтын асуудал эрхэлсэн сайд болон салбарын асуудал эрхэлсэн сайд
4	Аялал жуулчлалын хөгжлийн төсөл	Хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Салбарын асуудал эрхэлсэн Сайд
5	Дэд бүтцийн хөгжлийн төсөл	Хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Салбарын асуудал эрхэлсэн Сайд
II. Хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг			
6	Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	Хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны	Монгол Улсын Засгийн газар

		төв байгууллага болон Нийслэлийн Засаг дарга	
7	Чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	Хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Чөлөөт бүсийн ажлын алба	Хот байгуулалтын асуудал эрхэлсэн сайд болон салбарын асуудал эрхэлсэн сайд
8	Бүсийн хөгжлийн тулгуур төв хот, түүнчлэн томоохон уул уурхайн орд газар, үйлдвэр, нисэх онгоцны буудлыг даган хөгжих хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	Хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Аймаг, нийслэлийн Засаг дарга	Хот байгуулалтын асуудал эрхэлсэн Сайд болон салбарын асуудал эрхэлсэн Сайд
9	Онцгой зохицуулалттай объектын ерөнхий төлөвлөгөө	Хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Хот байгуулалтын асуудал эрхэлсэн Сайд болон салбарын асуудал эрхэлсэн Сайд
10	Шинэ хороолол, бичил хорооллын зураг төсөл, техникийн баримт бичиг болон гадаадын хөрөнгө оруулалттай байгууллагын боловсруулсан хот байгуулалтын баримт бичиг	Хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Хот, тосгоны захирагч, сум, дүүргийн Засаг дарга, Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитектор	Аймаг, нийслэлийн Засаг дарга
11	Орон нутгийн хот болон tosgoны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө	Хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Хот, тосгоны захирагч, сум, дүүргийн Засаг дарга, Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитектор	Аймаг, нийслэлийн Засаг дарга
12	Хот, тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө	Хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Хот, тосгоны захирагч, сум,	Аймаг, нийслэлийн Засаг дарга

		дүүргийн Засаг дарга, Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитектор	
13	Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө	Хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Дүүргийн Засаг дарга болон Нийслэл хотын ерөнхий архитектор	Нийслэлийн Засаг дарга
14	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл	Хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Хот, тосгоны захирагч, сум, дүүргийн Засаг дарга, Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитектор	Аймаг, нийслэлийн Засаг дарга

Барилга, хот байгуулалтын сайдын
2019 оны 9^д дугаар сарын 26-ны өдрийн
54 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ХОТ БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГТ ЭКСПЕРТИЗ ХИЙХ
ЭКСПЕРТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТҮҮНИЙГ ӨРСӨЛДӨӨНИЙ
ЖУРМААР СОНГОН ШАЛГАРУУЛЖ, ЭРХ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертийг сонгон шалгаруулах, эрх олгох үйл ажиллагааг зохион байгуулах, түүний хэрэгжилтийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертийг сонгон шалгаруулахад шударга, ил тод, адил тэгш хандах, нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгоно.

1.3. Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертийг сонгон шалгаруулах, эрх олгох, хүчингүй болгох үйл ажиллагааг хот байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна.

**Хоёр. Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертэд
тавигдах шаардлага**

2.1. Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертийн эрх олгох сонгон шалгаруулалтад энэ журмын 2.2-т заасан шаардлагыг хангасан иргэн оролцено.

2.2. Экспертиз хийх эксперт нь дараах шалгуурыг хангасан Монгол Улсын иргэн байна. Үүнд:

2.2.1. бүс нутаг, хот төлөвлөгч, архитектор, инженерийн мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн;

2.2.2. Барилгын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3.3-т заасан мэргэшлийн зэрэгтэй;

2.2.3. мэргэжлийн чиглэлээр салбартаа 15-аас доошгүй жил ажилласан байх;

2.2.4. хүн амын нутагшилт, суурьшил, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, бүс нутаг, аймаг, сумын хөгжлийн төсөл, хот, тосгоны хөгжлийн

ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, улс, нийслэл, аймаг, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 12-оос доoshгүй тооны зураг төсөл, мөн тооноос доoshгүй хот, суурин газрын геодезийн хэмжилт, зураглалын ажлыг бие даан буюу хамtran гүйцэтгэсэн, 3-аас доoshгүй тооны төслийг удирдсан буюу зургийн ерөнхий архитектороор ажилласан байх;

2.2.5.мэргэжлийн чиглэлийн 3-аас доoshгүй норм, дүрэм, заавар, стандарт, гарын авлагыг бие даан боловсруулсан буюу боловсруулахад хамtran оролцсон байх;

2.2.6.Барилгын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т заасан шаардлагыг хангасан байх;

2.2.7.зураг төслийн экспертизээр өмнө нь ажиллаж байсан бол гэрээний үүргээ зөрчөөгүй байх.

Гурав. Экспертиз хийх экспертийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

3.1.Хот байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх) нь хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг энэ журамд заасны дагуу зохион байгуулна. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тухай бүрт нь ажлын хэсгийг шинээр байгуулна.

3.2.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд салбарын эрдэмтэн, судлаач, мэргэшлийн зөвлөх зэрэгтэй мэргэжилтэн, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон газрын харилцаа, геодези, зураг зүй, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөллийг оролцуулна.

3.3.Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалттай холбоотой аливаа асуудлыг хурлаараа хэлэлцэн шийдвэрлэж, хурлын тэмдэглэл хөтөлнө.

3.4.Ажлын хэсэг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.4.1.сонгон шалгаруулалтыг зарлах;

3.4.2.сонгон шалгаруулалтад оролцогч (иргэн)-ийн материалыг хүлээн авах, бүртгэх, хянан үзэх;

3.4.3.иргэнд хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертийн эрх олгох дүгнэлт гаргах;

3.4.4.сонгон шалгаруулалтын дүнг олон нийтэд мэдээлэх;

3.4.5.сонгон шалгаруулалт зохион байгуулах байр, бусад шаардагдах нөхцөлийг хангах.

3.5.Ажлын хэсэг нь хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг ажлын 15 хоногт багтаан зохион байгуулна.

3.6.Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертийн сонгон шалгаруулалтыг жил тутам зохион байгуулж болно.

Дөрөв. Сонгон шалгаруулалтыг зарлах, материалыг хүлээн авах, бүртгэх

4.1.Ажлын хэсэг нь хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертийг сонгон шалгаруулах зарыг хуанлийн 14-өөс доошгүй хоногийн хугацаатай хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

4.2.Сонгон шалгаруулалтын зард тухайн оролцогч (иргэн)-д тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, хүлээн авах, бүртгэх, сонгон шалгаруулалт хийх байр, хугацаа, харилцах утасны дугаар зэргийг тодорхой заана. Уг зард өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд ажлын хэсгийн хурлаар шийдвэрлэж, энэ тухай нийтэд мэдээлнэ.

4.3.Сонгон шалгаруулалтад оролцогч иргэн нь энэ журмын 2.2-т заасан шаардлагыг хангаж буйг нотлох баримт бичгээс гадна дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна.Үүнд:

4.3.1.хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх эрх авах сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт (хувь хүний нэр дээр өргөдөл бичсэн байна);

4.3.2.анкет (Төрийн албан хаагчийн анкет №1 маягтын дагуу);

4.3.3.иргэний үнэмлэхний хуулбар хувь;

4.3.4.мэргэжлийн боловсролын гэрчилгээ, дипломын баталгаажуулсан хувь;

4.3.5.нийгийн даатгалын дэвтрийн баталгаажуулсан хувь;

4.3.6.мэргэшлийн зэргийн гэрчилгээний хуулбар хувь;

4.3.7.мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээний баталгаажуулсан хувь;

4.3.8.өөрийн мэргэжлийн хүрээнд зураг төсөл боловсруулах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил, бүтээлийн жагсаалтыг 2-оос доошгүй зөвлөх зэрэгтэй инженер, эдийн засагч, архитектороор баталгаажуулсан эх хувь.

4.4. Энэ журмын 4.3-д заасан баримт бичгийг сонгон шалгаруулалтад оролцогч иргэн нь үнэн зөв, бүрэн бүрдүүлж ажлын хэсэгт ирүүлэх бөгөөд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хүлээн авч бүртгэнэ.

Тав. Сонгон шалгаруулалтыг дүгнэх

5.1. Ажлын хэсэг хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертийн сонгон шалгаруулалтад оролцогч иргэн нь энэ журмын 2.2-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг ирүүлсэн материалд үндэслэн хянан үзэж, дүнг гаргана.

5.2. Сонгон шалгаруулалтын дүнг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн, экспертиз хийх экспертийн эрх олгох дүгнэлтийг гаргана. Уг дүгнэлтийг 2 хувь үйлдэж ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гарын үсэг зурна.

5.3. Ажлын хэсгийн дүгнэлтийг хот байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Зургаа. Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх иргэнд экспертийн эрх олгох

6.1. Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнд хот байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертийн эрхийг 3 (гурван) жилийн хугацаатай олгоно.

6.2. Сонгон шалгаруулалтад тэнцээгүй иргэн, хуулийн этгээдэд ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн хариуг албан бичгээр ажлын 5 хоногт багтаан мэдэгдэнэ.

6.3. Хот байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллагаас хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертийн эрх авсан иргэнд экспертийн үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдгийг олгож, мэдээллийн санд бүртгэнэ.

6.4. Хот байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллагаас хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертийн гэрээ байгуулж, жил бүр дүгнэн ажиллана.

6.5. Экспертийн бүртгэл, мэдээллийн санг хот байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллага хөтлөх бөгөөд холбогдох тайлан, мэдээг Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүр тайлagnана.

Долоо. Экспертийн эрхийг хүчингүй болгох

7.1.Экспертийн эрхийг хот байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр дараах тохиолдолд хүчингүй болгоно. Үүнд:

7.1.1.иргэн өөрөө хүсэлт гаргасан;

7.1.2.экспертийн үнэмлэх, хувийн тэмдгийг бусдад ашиглуулсан нь тогтоогдсон;

7.1.3.хот байгуулалтын баримт бичигт экспертизийн дүгнэлтийг буруу, алдаатай гаргасан нь холбогдох мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэгдсэн, мөн хот байгуулалтын төрийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын хяналт шалгалтын дүгнэлт болон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон;

7.1.4.өөрийн болон хамаарал бүхий этгээдийн хот байгуулалтын баримт бичигт экспертизийн дүгнэлт гаргасан;

7.1.5.шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр үйл ажиллагаа явуулах эрхийг нь хассан;

7.1.6.хот байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллагатай байгуулсан экспертийн гэрээг зөрчсөн;

7.1.7.экспертиз хийхээр хуваарилсан хот байгуулалтын баримт бичигт экспертизийн дүгнэлт гаргахаас хууль, эрх зүйн үндэслэлгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр З-аас дээш удаа татгалзсан.

7.2.Экспертийн эрх нь хүчингүй болсон иргэний бүртгэлийг мэдээллийн сангаас хасна.


Найм. Бусад

8.1.Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийх экспертийг сонгон шалгаруулхтай холбогдсон асуудлаар гаргасан маргааныг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

8.2.Эксперт (иргэн) нь өөрийн гаргасан экспертизийн дүгнэлтэд холбогдох хуулийн дагуу мэргэжлийн хариуцлагыг хүлээнэ.

“Хот байгуулалтын баримт бичигт
экспертиз хийх экспертэд тавигдах шаардлага,
түүнийг өрсөлдөөний журмаар сонгон шалгаруулж,
эрх олгох журам”-ын хавсралт

ХОТ БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН ЭКСПЕРТИЗИЙН БОЛОН ЭКСПЕРТИЙН ТЭМДГИЙН ДАРДАСНЫ ЗАГВАР



МОНГОЛ УЛС
Хот байгуулалтын баримт
бичгийн экспертизийн
ЭКСПЕРТ
Төрмөнх МӨНХБАТ
ХБ-01-015
/гарын үсэг/
он сар едер
2019-2022
0000000000

► Дотор хүрээний өргөн 4.3 см
зузаан 0.5
► Гадна хүрээний өргөн 4.8 см
зузаан 1.0



МОНГОЛ УЛС
ХОТ БАЙГУУЛАЛТ
ХБ 01-009
ЭКСПЕРТИЗ ХИЙГДСЭН
Улсын экспертизийн дүгнэлт №
Нэгжийн дарга /гарын үсэг/
он сар едер
0000000000

► Дотор хүрээний өргөн 6.2 см
зузаан 0.5
► Гадна хүрээний өргөн 6.8 см
зузаан 1.0

- 1 Монгол Улс бичвэр, усгийн хэмжээ -6
- 2 Хот байгуулалтын баримт бичгийн экспертизийн бичвэр, усгийн хэмжээ -5
- 3 Эксперт бичвэр, усгийн хэмжээ -7
- 4 Эцэг, эхийн болон өврийн нэрийн бичвэр, усгийн хэмжээ -7
- 5 Эксперт иргэний буртгэлийн дугаарын бичвэр, усгийн хэмжээ -5
- 6 Экспертиз хийсэн экспертийн гарын усгийн бичвэр, усгийн хэмжээ -6
- 7 Экспертиз хийсэн он сар өдрийн бичвэр, усгийн хэмжээ -5
- 8 Экспертиз хийх эрхийн хүчинтэй хугацааны бичвэр, усгийн хэмжээ -6
- 9 Улсын буртгэлийн хяналтын дугаарын бичвэр, усгийн хэмжээ -6

Жич. Тэмдэгийн дардас нь цэнхэр ёнгетэй байна.

- 1 Монгол Улс бичвэр, усгийн хэмжээ -6
- 2 Зохион байгуулагч байгууллагын нэрийн бичвэр, усгийн хэмжээ -7
- 3 Экспертизийн буртгэлийн дугаарын бичвэр, усгийн хэмжээ -6
- 4 Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийгдсэн тэмдэглэгээний бичвэр, усгийн хэмжээ -10
- 5 Экспертизийн ерөнхий дүгнэлтийн буртгэлийн дугаарын бичвэр, усгийн хэмжээ -6.5
- 6 Зохион байгуулагч байгууллагын экспертизийн асуудал хариуцсан нэгжийн даргын гарын бичвэр, усгийн хэмжээ -6.5
- 7 Экспертиз хийсэн он сар өдрийн бичвэр, усгийн хэмжээ -6
- 8 Улсын буртгэлийн хяналтын дугаарын бичвэр, усгийн хэмжээ -6

Жич. Тэмдэгийн дардас нь улаан ёнгетэй байна.



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛЫН САЙДЫН ТУНАЛД

2019 оны 03 сарын 26-ны өдөр

Дугаар 53

Улан-баатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалт, Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг хуулийн этгээдэд олгох, хяналт тавих журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (Ц.Ганхүү)-т, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Гүнболд)-т тус тус үүрэг болгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 212 дугаар тушаалаар баталсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам"-ын нэгдүгээр хавсралтад заасан хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох ажлын төрөл, суурь нөхцөл шаардлагын хот төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах ЗТ-9.1, 9.2-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Х.БАДЕЛХАН

ХОТ БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ЭРХИЙГ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хот байгуулалтын тухай хуулийн 7.1.4-д заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагад (цаашид “хуулийн этгээд” гэх) хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх (цаашид “эрх” гэх) олгох, бүртгэх, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, нөхөн олгох, хүчингүй болгох, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Энэ журмын хавсралтад заасан суурь нөхцөл, шаардлагыг хангасан хуулийн этгээдэд эрх олгоно.

1.3. Эрхийг Хот байгуулалтын тухай хуулийн 7.1.4-д заасны дагуу хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр олгож, хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.

1.4. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр эрх авсан хуулийн этгээд нь энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан ажлын төрлийн хүрээнд хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах үйл ажиллагаа эрхэлнэ.

1.5. Монгол Улсын нутаг дэвсгэрт хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй гадаадын хуулийн этгээд нь Хот байгуулалтын тухай хуулийн 11.2-т заасны дагуу хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан байна.

1.6. Эрх шинээр олгох, хугацааг сунгах, нөхөн олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон мэдээлэл нь олон нийтэд ил тод, нээлттэй байна.

1.7. Эрх олгох үйл ажиллагааг Хот байгуулалтын тухай хууль болон энэ журмаар зохицуулна.

Хоёр. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх авахад бүрдүүлэх баримт бичиг

2.1. Эрх авахаар хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ журмын 2.2-т заасан баримт бичгийг Хот байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллагад (цаашид “зохион байгуулагч байгууллага” гэх) бүрдүүлэн өгч, зохих журмын дагуу хүсэлтээ шийдвэрлүүлнэ.

2.2. Эрх шинээр авах, сунгуулах хүсэлт гаргах хуулийн этгээд нь дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

2.2.1. Эрх авахыг хүссэн өргөдөл (эрхлэх ажлын төрөл, хугацааг тодорхой дурьдсан байх);

2.2.2. Улсын бүртгэлийн гэрчилгээ;

2.2.3. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

2.2.4. Холбогдох ажлын төрөл, суурь нөхцөл, шаардлагын дагуу архитектор, инженер, техникийн ажилтан нэг бүрийн диплом, гэрчилгээ, батламж, мэргэшсэн болон зөвлөх инженерийн мэргэшлийн зэргийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар;

2.2.5. Архитектор, инженер, техникийн ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн ажилтан байх бөгөөд нийгмийн даатгалын лавлагаа буюу нийгмийн даатгалын дэвтрийн баталгаажуулсан хуулбар;

2.2.6. Програм хангамж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалт болон тодорхойлолт, үйлдвэрлэлийн байрны талаарх мэдээлэл;

2.2.7. Эрх сунгах болон ажлын төрлөөр нэмэлт заалт хүссэн хуулийн этгээдийн хувьд хот байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллагын мэдээллийн санд холбогдох журмын дагуу бүртгүүлсэн байх;

2.2.8. Хот төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй болон мэргэшсэн зэрэгтэй эдийн засагч нь хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх бүхий З-аас дээшгүй аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж болно. Хэрэв ийм тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, байгууллагын тодорхойлолтыг хавсаргана.

2.3. Гадаадын хуулийн этгээд эрх авах хүсэлт гаргахдаа энэ журмын 2.2-т заасан баримт бичгийг бүрдүүлэхээс гадна тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний баталгаат орчуулгын хуулбарыг хавсаргана.

2.4. Эрх авахыг хүссэн хуулийн этгээд нэг цэгийн үйлчилгээгээр үйлчлүүлэх үйлчилгээний хөлсийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 28.1.8-д заасан хэмжээгээр төлж баримтыг хавсаргана.

2.5. Энэ журмын 2.4-д заасан үйлчилгээний хөлсийг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр тогтоох бөгөөд нэг цэгийн үйлчилгээгээр иж бүрэн үйлчилгээ авснаас хойш 30 хоногийн дотор үйлчлүүлнэ.

Гурав. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх авах хүсэлтийг хянан шийдвэрлэх

3.1. Эрх авахыг хүссэн хуулийн этгээдийн өргөдлийг зохион байгуулагч байгууллага хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор мэдээллийн сантай тулгалт хийж, ажлын хэсгийн хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

3.2. Эрх олгохоос татгалзсан бол энэ тухай үндэслэлийг тодорхой зааж, зохион байгуулагч байгууллага хүсэлт гаргасан хуулийн этгээдэд албан бичгээр хариу мэдэгдэнэ.

3.3. Эрх авахыг хүссэн хуулийн этгээдийн бүрдүүлсэн баримт бичгийг холбогдох байгууллагаар шалгуулж, магадлан шинжилгээ хийлгэж болно. Энэ үйл ажиллагаа хийгдэж буй тохиолдолд өргөдлийг 14 хоногийн хугацаагаар сунгаж болно.

3.4. Зохион байгуулагч байгууллага эрх сунгахыг хүссэн хуулийн этгээдийн шаардлагатай мэдээллийг мэдээллийн санд оруулж, мэдээллийн иж бүрдлийн үнэн зөв байдлыг хянаж, баталгаажуулна.

3.5. Мэдээллийн санд бүртгүүлсэн мэдээлэл алдаатай, зөрүүтэй, шаардлага хангагүй нөхцөлд мэдээллийг тодруулах буюу засварлуулахаар буцаах ба мэдээлэл үнэн зөв бүрдэх хүртэл хүсэлт баталгаажихгүй. Энэ талаар зохион байгуулагч байгууллагын албан ёсны цахим хаягаар хариуг хүргүүлнэ.

Дөрөв. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх олгох

4.1. Эрх олгох үйл ажиллагаанд улс орны батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах, нийтийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, ил тод, нээлттэй, шуурхай, аж ахуй эрхлэх таатай орчныг бүрдүүлэх зарчмуудыг баримтална.

4.2. Эрхийг таван жилийн хугацаатайгаар олгож, мөн хугацаагаар сунгаж болно.

4.3. Эрхийн гэрчилгээ нь үнэт цаасан дээр хэвлэгдэх бөгөөд дараах мэдээллийг тусгана:

4.3.1. эрх олгосон байгууллагын нэр;

4.3.2. эрх эзэмшигчийн нэр, хаяг;

4.3.3. эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрөл;

4.3.4. эрхийн хугацаа;

4.3.5. эрхийн хүрээнд эрхлэх аж ахуйн үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага;

4.3.6. эрхийн дугаар, олгосон он, сар, өдөр;

4.3.7.эрх олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга (тэмдэг).

4.4.Хуулийн этгээдэд эрх олгох, сунгах, хүчингүй болгох үйл ажиллагааг хариуцах ажлын хэсэг (цаашид “Ажлын хэсэг” гэх)-ийг хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр байгуулан ажиллуулна.

4.5.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хот байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллага, салбарын мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага болон болон хот байгуулалтын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын төлөөллийг оролцуулна.

4.6.Ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, дүгнэлтэд дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж албажуулна. Ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, дүгнэлт нь ажлын хэсгийн албан хэрэгцээнд болон эрх олгох тушаал бүрийн эх хувийн хамт архивт хадгалагдана.

4.7.Зохион байгуулагч байгууллагын мэдээллийн сангаас баталгаажуулж ирүүлсэн хуулийн этгээдийн эрх авахыг хүссэн баримт бичиг нь энэ журмын 1.2-т заасан суурь нөхцөл, шаардлагыг хангаж байгааг ажлын хэсэг хянан хэлэлцээд, эрх олгох эсэх талаар дүгнэлт гаргана.

4.8.Ажлын хэсгийн гаргасан дүгнэлтийг Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн танилцуулж, хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулна.

4.9.Эрхийг шинээр олгох шийдвэрийн дагуу эрх авсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулагч байгууллага ажлын 5 хоногт багтаан гүйцэтгэнэ.

4.10.Эрх авсан хуулийн этгээдтэй байгуулах гэрээнд дараах асуудлыг тусгана:

4.10.1.холбогдох хууль тогтоомж болон дүрэм, журам, норм, нормативын баримт бичиг, стандартыг баримталж ажиллах;

4.10.2.зөвлөх болон мэргэшсэн, бусад инженер техникийн ажилтны шилжилт хөдөлгөөний өөрчлөлтийн тэмдэглэлийг хийлгэх;

4.10.3.мэдээллийн санд хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийг тогтоосон хугацаанд ирүүлэх;

4.10.4.зураг төслийн үйлдвэрлэлд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх дүрэм, журмыг баримталж ажиллах;

4.10.5.техникийн дотоодын хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах;

4.10.6.ажилтнуудыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулах;

4.10.7 хуульд заасан бусад эрх, үүрэг, хариуцлага.

Тав. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг сунгах, нөхөн олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

5.1.Эрх авсан хуулийн этгээд хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийн хугацааг 5 жилийн хугацаагаар сунгуулах хүсэлтийг зохион байгуулагч байгууллагад гаргана.

5.2.Эрх сунгуулах хүсэлтийг гаргахдаа энэ журмын 1.2-т заасан хуулийн этгээдэд тавигдах шаардлагын дагуу инженер, техникийн ажилтнуудын мэдээллийг цахим мэдээллийн санд оруулсан байна. Зохион байгуулагч байгууллага нь мэдээллийн санд цахимаар бүртгүүлсэн мэдээллийг баталгаажуулан энэ журмын 3.1-д заасантай адил хугацаанд ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

5.3.Эрх сунгуулах хуулийн этгээд нь хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаа эрхэлсэн ажлын тайлан, мэдээг мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

5.4.Хуулийн этгээд нь хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийн суурь нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд хот байгуулалтын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зохион байгуулагч байгууллагын албан бичгийг үндэслэн тухайн олгосон эрхийг сунгахаас татгалзана.

5.5.Эрхийг сунгахаас татгалзсан бол зохион байгуулагч байгууллага хүсэлт гаргасан хуулийн этгээдэд албан бичгээр хариу мэдэгдэнэ.

5.6.Хуулийн этгээд нь хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийн гэрчилгээг гээж, үрэгдүүлсэн шалтгаанаар нөхөн олгуулах хүсэлт гаргасан бол гэрчилгээгээ үрэгдүүлсэн тухайгаа өдөр тутмын сонинд зарлаж, сонингийн хамт нөхөн олгох хүсэлтээ зохион байгуулагч байгууллагад ирүүлнэ. Зохион байгуулагч байгууллага ирүүлсэн холбогдох материалыг хянан ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлж., ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр гэрчилгээг нөхөн олгоно.

5.7.Эрх авсан хуулийн этгээдийн оноосон нэр өөрчлөгдсөн шалтгаанаар нөхөн олгуулах хүсэлт гаргасан бол хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн тухай Улсын бүртгэлийн ерөнхий газрын лавлагаа, аж ахуйн нэгжийн шинэ гэрчилгээ, дүрмийн хуулбар, энэ журмын 2.2-т заасан баримт бичгийг бүрдүүлж, зохион байгуулагч байгууллагад ирүүлнэ. Зохион байгуулагч байгууллага холбогдох

материалыг хянан ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлж, ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр гэрчилгээг нөхөн олгоно.

5.8.Хуулийн этгээд нь олгосон эрхийн хугацаа, суурь нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд хот байгуулалтын улсын хяналт хэрэгжүүлэгч байгууллагын дүгнэлтийг үндэслэн 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно. Энэ асуудлыг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлж, ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулна.

5.9.Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тухайн хуулийн этгээдийн эрхийг түдгэлзүүлсэн хугацаа дуусгавар болсон тохиолдолд эрхийг сэргээнэ.

5.10.Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах тохиолдолд хуулийн этгээдэд олгосон эрхийг хүчингүй болгоно:

5.10.1.эрх авсан хуулийн этгээд хүсэлт гаргасан;

5.10.2.хуулийн этгээд татан буугдсан;

5.10.3.эрх авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

5.10.4.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийн суурь нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

5.10.5.олгосон эрхийн хүрээнд заасан үйл ажиллагааг 5 жил дараалан эрхлээгүй;

5.10.6.Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлд тавьсан шаардлагыг зөрчсөн;

5.10.7.эрх түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

5.11.Энэ журмын 5.13-д заасан үндэслэлээр хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг хүчингүй болгох асуудлыг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлж, дүгнэлтийг гаргана. Ажлын хэсгийн дүгнэлтийг хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулна.

5.12.Эрх авсан хуулийн этгээд хот байгуулалтын баримт бичиг боловсруулах үйл ажиллагааны мэдээ, тайланг 1 жилээс дээш хугацаанд мэдээллийн санд ирүүлээгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу холбогдох арга

хэмжээ авхуулах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлнэ. Энэ нь тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэл болно.

5.13.Эрхийг хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн эрх бүхий албан тушаалтын шийдвэр гарснаас хойш ажлын З өдрийн дотор эрх эзэмшигч болон харьяалах татварын албанд Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага албан бичгээр мэдэгдэнэ.

Зургаа. Эрх авсан хуулийн этгээдийн баримт бичгийг баяжуулах, хадгалах

6.1.Зохион байгуулагч байгууллага эрх авсан хуулийн этгээдийн талаарх мэдээллийг шинэчлэх, баяжуулах, холбогдох өөрчлөлтийг хийх, мэдээллийн сангийн тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, мэдээллийн үнэн зөвийг хариуцаж, бусад байгууллага, иргэдийг мэдээллээр хангаж ажиллана.

6.2.Эрх авсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх, тайлан, мэдээ гаргах, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, мэдээллийн санг бүрдүүлэн хотлох, цахимжуулах, тэдгээрийн үр дүнг Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулагч байгууллага хариуцна.

Долоо. Бусад

7.1.Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

7.2.Хуулийн этгээд эрх олгох, сунгах, түдгэлзэх, хүчингүй болгохтой холбогдон гарсан санал, өргөдөл, гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохих шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

-----оОо-----

“Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах
эрхийг хуулийн этгээдэд олгох, хяналт тавих
журам”-ын хавсралт

ХОТ БАЙГУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ЭРХИЙГ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ОЛГОХ АЖЛЫН ТӨРӨЛ, СУУРЬ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

Нэг. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлын хүрээнд:

Ажлын төрөл	Байвал зохих инженер, техникийн ажилтан	Инженер, техникийн ажилтны ажлын туршлага, тавигдах шаардлага
ХБ-1.1. Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, хот төлөвлөлтийн суурь судалгаа	<p>Хот төлөвлөлтийн архитектор - 8, Хот төлөвлөлтийн эдийн засагч - 3, Газар зохион байгуулагч - 2, Газарзүйч - 1, Экологич - 1, Барилгын инженер - 1, Ус хангамж, ариутгах татуургын инженер - 2, Цахилгааны инженер - 2, Холбоо, дохиоллын инженер - 2, Дулааны инженер - 2, Усны инженер - 1 Зам, гүүрийн инженер - 1, Тээврийн инженер - 1, Геодезийн инженер - 1, Инженер- геологийн инженер - 1 Зургийн техникч - 4.</p>	<p>Хот төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй архитектор - 2, Мэргэшсэн зэрэгтэй архитектор - 4, Хот төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй эдийн засагч - 1, Барилгын мэргэшсэн зэрэгтэй инженер - 1, Ус хангамж, ариутгах татуургын мэргэшсэн зэрэгтэй инженер - 1, Цахилгааны мэргэшсэн зэрэгтэй инженер - 1, Холбоо, дохиоллын мэргэшсэн зэрэгтэй инженер - 1, Дулааны мэргэшсэн зэрэгтэй инженер - 1, Усны мэргэшсэн зэрэгтэй инженер - 1, Геодезийн мэргэшсэн зэрэгтэй инженер - 1, Инженер геологийн мэргэшсэн зэрэгтэй инженер - 1, Зам, гүүрийн зураг төслийн мэргэшсэн зэрэгтэй инженер - 1 байна.</p> <p>Геодезийн хэмжилт, зураглал, зураг зүй, инженер хайгуул, байгаль орчны үнэлгээний хэсгийг тусгай зөвшөөрөлтэй буюу эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлнэ.</p>

ХБ-1.2. Бус нутгийн хөгжлийн төсөл, аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, хот төлөвлөлтийн суурь судалгаа	Хот төлөвлөлтийн архитектор - 2, Ландшафтын архитектор - 1, Хот төлөвлөлтийн эдийн засагч - 1, Газар зохион байгуулагч - 1, Газарзүйч - 1, Экологич - 1, Дэд бүтцийн асуудал хариуцсан инженер - 1, Геодезийн инженер - 1.	Хот төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй архитектор - 1, Мэргэшсэн зэрэгтэй архитектор - 1, Хот төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй эдийн засагч - 1, Газар зохион байгуулалтын мэргэшсэн зэрэгтэй инженер - 1, Геодезийн мэргэшсэн зэрэгтэй инженер - 1 байна. <i>Геодезийн хэмжилт, зураглал, зураг зүй, инженер хайгуул, дэд бүтэц, байгаль орчны үнэлгээний хэсгийг тусгай зөвшөөрөлтэй буюу эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлнэ.</i>
ХБ-1.3. Чөлөөт бус, хот, тосгоны ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, хот төлөвлөлтийн суурь судалгаа, хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Хот төлөвлөлтийн архитектор – 2, Ландшафтын архитектор - 1, Хот төлөвлөлтийн эдийн засагч - 1.	Хот төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй архитектор - 1, Хот төлөвлөлтийн эдийн засагч нь мэргэшсэн зэрэгтэй байна. <i>Геодезийн хэмжилт, зураглал, зураг зүй, газар зохион байгуулалт, инженер хайгуул, дэд бүтцийн хэсгийг тусгай зөвшөөрөлтэй буюу эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлнэ.</i>

-----оОо-----